

бодхийн бүрдэлтэй хувьсаж хөгжихийн хирээр нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн үүрэг өсч байна. Мэргэжлийн үйлчилгээний уламжлалт үүрэг нь хөрөнгө санг барих, хяналт тавих явдлыг голчилсон, өөрөөр хэлбэл “бүртгэх тэмдэглэх” шинжтэй байсан бол аж ахуй эрхлэлтийн өнөөгийн нөхцөлд бүтэц агуулга нь их өөрчлөгдөн удирдлагын үйлдлийн цоо шинэ төрөл, бүтэц бүрэлдэн тогтох байна.

7

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Л.Наранчимэг

Байгууллагын үйл ажиллагаа хувьсаж хөгжихийн хирээр нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн үүрэг өсч байна. Мэргэжлийн үйлчилгээний уламжлалт үүрэг нь хөрөнгө санг барих, хяналт тавих явдлыг голчилсон, өөрөөр хэлбэл “бүртгэх тэмдэглэх” шинжтэй байсан бол аж ахуй эрхлэлтийн өнөөгийн нөхцөлд бүтэц агуулга нь их өөрчлөгдөн удирдлагын үйлдлийн цоо шинэ төрөл, бүтэц бүрэлдэн тогтох байна.

Энэхүү шинэ төрөл нь өнгөрсөн ба өнөөгийн төдийгүй ирээдүйд чиглэсэн бөгөөд санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх алхамтай нягт уялдах болсоноор санхүүгийн үзүүлэлтийг тооцох, олон улсын стандартад нийцүүлэн санхүүгийн тайланг гаргах, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын нөөцийг зохицуулах гэхчилэн зөвхөн цаг үеийн шуурхай зохицуулалтын хүрээнээс хальж илүү стратегийн шинжтэй болж байна.

Энэ нөхцөл байдалтай уялдан удирдлагын шийдвэр гаргах, стратеги зорилтыг тодорхойлоход аль болох ойртож очихуйц тийм удирдлагын мэдээллийн шинэ тогтолцоог боловсруулах шаардлага тавигдах боллоо. Энэ тогтолцоонд нягтлан бодогч нь “мэдээллийн ургалын зохион бүтээгч”ийн үүргийг өөртөө авах ёстай. Тухайлбал: санхүүгийн шинжилгээ хийж, санхүүгийн төсөв төлөвлөгөө зохиох, үйл ажиллагааг урьдчилан төсөөлж тооцоолоход нягтлан бодох бүртгэлийн тоо мэдээг чадмаг ашиглах ур чадварыг эзэмшсэн байх нь нягтлан бодогчийн нэг чухал шинж, мэргэжлийн ур чадварын хэмжүүр болно.

Ерөнхий нягтлан бодогчийн мэргэжлийн үйлчилгээний хүрээг бүртгэл тооцооны үүргээс удирдлагын шийдвэр боловсруулах хүрээнд шилжүүлж ойлгох хэрэгцээ, шаардлага энд хөндөгдөж буй. Нягтлан бодох бүртгэлийн үндэсний хууль эрх зүйн актуудад ерөнхий нягтлан бодогчийн ажил үүргийн дотор байгууллагын тогтвортой үйл ажиллагааг хангахын тулд санхүүгийн нөөцийг арвижуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэйг заах болсон нь санамсаргүй хэрэг биш.

Сүүлийн үед байгууллагын үндсэн шинж чанарыг тодорхойлоходоо тодорхой чиг зорилготой байхаас гадна тогтвортой байдлыг нэн түрүүнд чухалчилдаг болсон нь ажиглагдаж байна. Тогтвожилтын мөн чанар нь түгээмэл шинжтэй бөгөөд тодорхой чиг зорилготой байх, дотоод нөөц боломж болон хүрээлэн буй орчны хувьсагчуудын тэнцвэрийг зөв тогтоохын төлөөх байнгын тэмцэл гэсэн байр сууринаас эдийн засгийн нэгжийн тодорхойлолтыг гаргах нь түлхүүр асуудал гэж болно. Тогтвортой байдлыг тусгаар нэгжүүдийн үйл ажиллагаа, хөгжлийн тодорхой бус байдлыг танин мэдэх үндсэн дээр шинжлэн судалж болно. Тодорхой бус хүчин зүйлсийн илрэл, үйлчлэл ба нөлөөллийн цар хүрээ, гонцлогууд нь удирдлагын чиг үүрэг, арга хэрэглүүр, механизмыг судлахад зарчмын ач холбогдолтой юм. Энэ бүхний хамгийн гол онцлог нь байгууллагын зохион байгуулалт, зохицох механизм, төрх байдал нь байнга өөрчлөгдсөөр байгаа явдал юм. Тодорхой бус байдлын янз бүрийн илрэлийг удирдлагын үзэл санааны үүднээс 2 үндсэн төрөлд хуваан авч үзэж болно.

- Үйл явцын тодорхой бус нөхцөл
- Үйл ажиллагааны үр дүнгийн хараахан тодорхой бус байдал

Удирдлагын үйл явцын тодорхойгүй байдал нь удирдлагын нөлөөлөх үйлдлийн бүрэлдэхүүн, хэрэгжих үе шат, дараалал, нөлөөлөх цаг хугацаа нь урьдчилан заагдаагүй байдгаар, үйл явцын тодорхойгүй шинж нь үйл ажиллагааны тодорхойгүй байдал, сонголт чөлөөтэй, технологи ажиллагааны олон хувилбартай байдлаар тодорхойлогдох жишээтэй.

Үр дүнгийн тодорхой бус шинжийг гаргасан шийдвэрээс гарах үр дагавар, удирдлагын нөлөөлөх үйл явц, аливаа үйл ажиллагааны хүлээгдэж буй үр дүнгийн бодит хэмжил тодорхой бус байдгаар тайлбарлаж болно. Үйл ажиллагааны болон үр дүнгийн тодорхой бус байдал нь диалектик нэгдэлтэй зүйл учраас “аж ахуйн тодорхой бус нөхцөл” гэсэн нэг ойлголтод багтаан авч үзэж болох юм. Судалгааны зорилготой уялдуулж үзвэл санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээ, түүнийг урьдчилан тесөөлөхөд ашиглах загварыг зөв томъёолж ашиглах асуудал чухал боллоо.

Удирдлагын шийдвэрийг оношлох, улам нарийвчлан авч үзэх, бүтцээр нь танин мэдэхэд орчны тодорхойгүй байдлыг нэн түрүүн харгалзан үзэх нь тогтвортгүй байдлаас сэргийлэх стратеги зорилтыг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл юм. Санхүүгийн тогтвортой байдлыг бүрдүүлэх, түүнийгээ улам бүр бэхжүүлэхийн тулд удирдлагын шийдвэрийг шинжлэн оношлох, загварчлан тесөөлөх, зэрээр тал бүрээс нь судлан боловсруулах үндсэн дээр шийдвэр гаргах нь өөр хоорондын нягт уялдаа холбоо бүхий олон талт зорилтыг хэрэгжүүлснээр ажил хэрэг болно.

Шинжилгээний зорилго ажлын зохион байгуулалт, мэдээлэл цугларуулах болон боловсруулах горим нь бусад боломжийг харгалзан тавьсан зорилтыг нарийсан тодорхойлсон зүйл юм. Дэвшүүлж буй байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг шинжлэх аргачлал нь санхүүгийн үр дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлэх боломжтой юм.

Эдийн засгийн иж бүрэн шинжилгээний нэг хэсэг нь үндсэн үзүүлэлтүүдийн параметр (индикаторийн) шинжилгээ юм. Энэ шинжилгээг онцгойлон авч үзэж байгаа нь:

1. Эдийн засгийн үзэгдлийг харилцан холбоо хамааралтай, эдийн засгийн бодит хууль, хүчин зүйлсийн үйлчлэлийн нөлөөлөлд авч судлах
2. Хүчин зүйлсийн эзэр нөлөөллийг илрүүлж эдийн засагт хэрхэн нөлөөлснийг нь тооцоолон хэмжих
3. Эдийн засгийн хөгжлийн тэнцвэр, хандлагыг тодорхойлох, ашиглагдаагүй нөөц боломжийг тооцоолон илрүүлэх
4. Маркетингийн стратеги, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэлд бодитой үнэлэлт өгөх
5. Үйлдвэрлэл аж ахуй санхүүгийн үйл ажиллагааны удирдлагын нэн хариуцлагатай алхам болох зохих үндэслэлтэй зөв шийдвэр гаргах зэрэг шинжилгээний үндсэн зорилтуудтай холбоотой юм. Параметрийн шинжилгээний судлах зүйл нь байгууллагын үйл ажиллагаа, бодитой болон хийсвэр хүчин зүйлсийн нөлөөгөөр бий болж улмаар нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлд тусгалаа олсон үйл ажиллагааны үр дүн юм. Санхүүгийн тогтвортой байдлын стратеги удирдлагын үүднээс авч үзвэл параметр шинжилгээний зорилго нь:

1. Санхүүгийн тогтвортой байдлыг үйл ажиллагааны үндсэн параметрүүдээр оношлох. Оношлоно гэж байгууллага дампуурах болон хүндрэлд орохын өмнө мэдрэгдэх “муу дохиог” урьдчилан илрүүлэх гэсэн үг. Эдийн засгийн агуулгын хувьд энэ зорилт нь шуурхай бөгөөд “анагаах, эрүүлжүүлэх” шинжтэй юм. Ийнхүү эртлэн оношлосноор ирээдүйн учрах дампуурлаас сэргийлэх санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлст үнэлгээ өгөх, нөхцөл байдалд зөв зохицон ажиллах, удирдлагын нэгэнт гаргасан шийдвэрийн үр дагаврыг тодорхойлох боломж бүрдэнэ.

2. Санхүүгийн тогтвортой, найдвартай байдлыг нарийвчлан шинжлэх. Энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд хүчин зүйлс тус бүрийн хэрхэн нөлөөлснийг нэг бүрчлэн тооцоолж хэмжинэ гэсэн үг юм.

3.Хөгжлийн стратегийг үндэслэх, сонгох. Энэхүү зорилтыг хийсэн шинжилгээний тодорхой үр дүнтэй, тэрчлэн байгууллагын эрмэлзэх зүйлтэй холбож үзвэл зохино. Энэхүү зорилго нь:

- a. Ашигт ажиллагааны наад захын түвшинг тогтоон барьж, ханган ажиллах замаар байгууллагын амьдрах нөхцлийг бүрдүүлэх
- b. Борлуулалтыг өсгөх, хөрөнгө нөөцийн эргэцийг хурдасгах замаар ашигт ажиллагааны ирээдүйн эзэр хандлагыг хангах явдал юм.
- 4.Тогтвортгүй байдлаас сэргийлэх, улмаар хямралт байдал, дампууралд хүргэж буй нөхцлөөс хурдан гарах,
5. Санхүүгийн ирээдүйн үр дүн түүнийг ашиглах үндсэн чиглэлийг урьдчилан таамаглах үүний тулд үйл ажиллагааны үндсэн параметрүүдийн ирээдүйн хүрэх түвшинг урьдчилан төсөвлох
6. Хөрөнгө эх үүсвэрийг зохицуулах удирдлагын зорилтуудыг тодорхойлох
7. Хөгжлийн стратеги болон цаг үеийн бодлогыг хэрэгжүүлэх удирдлагын шийдвэрийг төгөлдөржүүлэх, оновчтой болгох

Параметр шинжилгээ нь стратегийн болон цаг үеийн бодлогын үндсэн объект, хэмжлүүдийн үнэлгээ, тооцоолол хийх аргын цогц нэгдэл. Энэ нь байгууллагын үндсэн зорилгод нийцүүлэн үйлдвэрлэл аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг зорилго, чиглэлтэйгээр удирдан хөтлөх өөрчлөн шинэчлэхэд чиглэгдэнэ.

Санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх экспресс оношлогооны арга

Экспресс оношлогооны зорилго нь байгууллагын санхүүгийн тогтвортой байдлаа алдаж болзошгүй “муу дохио”г илрүүлэх явдал мөн. Байгууллагын санхүүгийн тогтвортой байдал бол эрэлт, худалдан авах чадвараар баталгаажсан өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн тийм эдийн засаг, санхүүгийн байдал юм. Санхүүгийн тогтвортой байдалд хийх шинжилгээ нь дараах хоёр үндсэн үе шатаар хийгдэнэ. Үүнд:

- Санхүүгийн тогтвортой байдлыг харуулах үзүүлэлтүүдийг шинжлэх
 - Байгууллагын тогтвортой байдалд хүргэх магадлалд үнэлгээ өгөх
- Эхний шатанд шинжилгээний тооцоо дараах хүрээнд хийгдэнэ.
- Үйл ажиллагааны ашигт ажиллагааг судлах
 - Байгууллагын ажил хэрэгч байдал, идэвхжилийг шинжлэх
 - Хөрөнгийн хөрвөх чадвар, төлбөрийн чадварыг шинжлэх
 - Санхүүгийн харьцааны холбогдох үзүүлэлтүүдийг шинжлэх


Үйл ажиллагааны ашигт ажиллагааны үзүүлэлтийг шинжслэх нь

Ашигт ажиллагаа бол үйл ажиллагааны өгөөжийг харуулах үзүүлэлт мөн. Жишээ болгон авсан “Х” компанийн ашигт ажиллагааны үзүүлэлтүүдийн 5 жилийн динамикийг авч үзье.

Хүснэгт 1

| Үзүүлэлтүүд | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 |
|----------------------------------|-------|------|-------|------|-------|
| Хөрөнгийн нийт ашигт ажиллагаа | 9.64 | 2.75 | 0.26 | 1.5 | -2.9 |
| Хөрөнгийн цэвэр ашигт ажиллагаа | 8.2 | 2.29 | -0.53 | 0.49 | -2.72 |
| Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа | 16.48 | 3.64 | 0.4 | 2.21 | -4.35 |
| Нийт ашгийн түвшин | 2.42 | 1.29 | 0.1 | 0.42 | -0.95 |
| Цэвэр ашгийн түвшин | 2.06 | 1.08 | -0.2 | 0.14 | -0.89 |
| Үйл ажиллагааны ашигт ажиллагаа | 2.51 | 1.32 | 0.1 | 0.43 | -0.95 |

Зураг 1. ААТ-ийн үндсэн үзүүлэлтүүд



Дээрх хүснэгтээс ашигт ажиллагааны ихэнх үзүүлэлтүүд буурах хандлагатай байна. 2001 онд ашигт ажиллагааны үзүүлэлтүүд харьцангуй хэвийн байж 2005 онд бүх үзүүлэлт сөрөг утга (алдагдалтай) авсан байна. Өөрийн хөрөнгийн өгөөж 5 жилд 20 хувь буурсан нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үүднээс авч үзэхэд байгууллагын үйл ажиллагааны эцсийн үр дун /өгөөж/ хэвийн бус байна гэсэн дүгнэлт хийх үндэс бүрдэж байна.

Ажил хэрэгч байдал /Оруулсан хөрөнгийн ашиглалт/

Үйл ажиллагаанд сонгож авсан стратеги ямар байгааг үнэлэх үүднээс ажил хэрэгч байдлыг харуулах зарим үзүүлэлтүүдийг хөндөж үзье.

Хүснэгт 2

| Үзүүлэлтүүд | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 |
|--|-------|-------|-------|-------|-------|
| 1.Хөрөнгийн капитал өгөмж | 3.97 | 2.12 | 2.69 | 3.57 | 3.04 |
| Хөрөнгийн эргэлтийн хугацаа (өдөр) | 92 | 172 | 136 | 102 | 120 |
| 2.Эргэлтийн бус хөрөнгийн өгөмж | 8 | 2.79 | 3.96 | 5.34 | 4.59 |
| Эргэлтийн бус хөрөнгийн эргэлтийн хугацаа (өдөр) | 46 | 131 | 92 | 68 | 80 |
| 3.Эргэлтийн хөрөнгийн эргэц | 7.9 | 8.86 | 8.4 | 10.76 | 9.01 |
| Эргэлтийн хөрөнгийн эргэц (өдөр) | 46 | 41 | 43 | 34 | 41 |
| 4.Материаллаг нөөцийн эргэц | 22.36 | 14.87 | 13.88 | 26.73 | 20.8 |
| Материаллаг нөөцийн эргэц (өдөр) | 16 | 25 | 26 | 14 | 18 |
| 5.Авлагын эргэц | 12.27 | 25.33 | 22.37 | 20.25 | 17.07 |
| Авлагын эргэц (өдөр) | 30 | 14 | 16 | 18 | 21 |
| 6.Өр төлбөрийн эргэц | 11.57 | 8.63 | 7.86 | 11.69 | 9.89 |
| Өр төлбөрийн эргэц (өдөр) | 32 | 42 | 47 | 31 | 37 |

Хүснэгтээс бизнесийн ажиллагааны идэвхжил өндөр буй хэдий ч материаллаг нөөцийн эргэцийн үзүүлэлтүүд тогтвортой бус байна. Дурьсан хугацаанд нөөцийн эргэцийн үзүүлэлтүүд жигд биш өөрчлөлттэй байна. (Зураг 2) Авлагын данс, материаллаг нөөцийн эргэц түргэссэн боловч бусад эргэцийн үзүүлэлтүүд удаашрах хандлагад орсон нь ажил хэрэгч байдлын түвшний хувьд тус байгууллага тогтвортой байдлаа алдахад хүрч болзошгүй байна.



Үйл ажиллагааны эцсийн үр дүн эргэцийн шинжилгээг тодруулах зорилгоор байгууллагын мөнгөн циклийн үе шатуудын хугацааг авч үзье.

Хүснэгт 3

| Үзүүлэлтүүд | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 |
|---|------|------|------|------|------|
| 1.Үйл ажиллагааны циклийн хугацаа(материаллаг зүйлс авахад мөнгө зарцуулах үеэс мөнгө эргэж орох хүртэл) | 46 | 41 | 44 | 34 | 41 |
| 2.Үйлдвэрлийн циклийн хугацаа (материаллаг нөөцийн эргэлтийн бүрэн цикл) | 16 | 25 | 26 | 14 | 18 |
| 3. Санхүүгийн циклийн үргэлжлж хугацаа(өдрөөр) | 14 | -3 | -3 | 0 | 2 |

Материаллаг нөөц байнга нөхөн сэлбэгдэж, өглөг авлагын барагдуулалтанд саад бэрхшээл бага байгаа нь санхүүгийн циклийн хугацаа тэгтэй тэнцүү байгаагаас харагдаж байна. Энэ бүхэн нь байгууллагын үйл ажиллагаанд таатай нөхцөл бүрдүүлж өгсөн байна. Активын ашигт ажиллагааг тодорхойлох томъёо нь:

$$Ra = BP / B * 100\% * B / A = Rn * OA$$

Ra - Хөрөнгийн ашигт ажиллагаа

BP - Балансын ашиг

B - Борлуулалтын орлого

A - Хөрөнгийн хэмжээ

Rn - Борлуулалтын ашигт ажиллагаа

OA - Хөрөнгийн эргэц

Энэхүү томъёоны хоёрдмол хэмжилд тулгуурлан хөрөнгийн ашигт ажиллагааг шийдвэрлэж болно. Дээрх хэмжилээр байж болох эсвэл, үйл явцын зорилтот түвшинг тогтоож болох юм. Гэхдээ зөвхөн орлого нэмэгдүүлэх гэх мэт өрөөсгөл шийдвэр гаргавал санхүүгийн үр дагавар нь сөрөг нөлөө үзүүлж болох талтай. Тухайлбал: орлогоо нэмэгдүүлэхийн тулд оруулах хөрөнгө нөөцөө өсгөвөл цаашид үйл ажиллагааны өсөлт тутамд их хэмжээний хөрөнгө хүч шаардагдсан эрчимт бус арга болно.. Орлогын өсөлтөнд голчлон дотоод хүчин зүйлс нөлөөлдөг, гэхдээ салбарын харьяалал зэрэг гадны хүчин зүйл ч нөлөөлж болох юм. Өнгөрсөн хугацаанд тус байгууллага нь хөрөнгийн эргэцийг хурдаасах замаар үйл ажиллагааны өсөлтийг хангаж ирсэн нь харагдаж байна. Үйл ажиллагааны үр ашиг, тогтвортой ашиг олох боломж бүрдүүлж байгаа бол хангамжийн үйл ажиллагаанд ийм чиглэл барих нь зөв байж болох юм. Хэрэв хөрөнгө нөөцийн байр сууриа өргөжүүлж өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл эс явуулах юм бол хэвийн үйл ажиллагааны нөхцөл хүрээгээ алдаж аж ахуй эрхлэх үйл явцын хямралт байдалд орж мэдэхийг үгүйсгэхгүй. юм. Дээрхи загвараас үндэслэн хөрөнгө нөөцийн ашиглалтын үр ашигийг дээшлүүлэх үндсэн нөхцөл бол үйл ажиллагааны илүү шинэ дэвшилттэй хүрээг сонгон нэвтрүүлэх замаар борлуулалтын ашигт ажиллагааг хангах явдал мөн гэсэн дүгнэлт гаргаж болно.

Хөрөнгийн хөрвөх чадвар, төлбөрийн чадварыг шинжлэх

Хүснэгт 4

| Үзүүлэлтүүд | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 |
|------------------------------------|--------|--------|--------|--------|--------|
| Эргэлтийн харьцаа | 1,21 | 0,97 | 0,94 | 1,04 | 1,02 |
| Өөрийн хөрөнгийн хангалтын коэф | 0,17 | -0,03 | -0,07 | 0,03 | 0,01 |
| Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа | 0,0001 | 0,0526 | 0,0181 | 0,0687 | 0,0405 |
| Төлбөр барагдуулах ойрын боломж | 0,78 | 0,39 | 0,37 | 0,62 | 0,58 |

Тус байгууллагын төлбөрийн чадвар тийм ч сайнгүй гэж үзэх болохоор байна. Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа доогуур байгаа нь өөрийн хөрөнгө, төлбөрийн хэрэгсэлийн (мөнгө)-ийн хүрэлцээ хангалтгүй байгааг нотолж байна.

Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүдийг шинжлэх

Санхүүгийн тогтвортой байдал нь хөрөнгө капиталын бүтэц, тухайн байгууллага нь санхүүжилтын гадны эх үүсвэрээс хэр хамааралтай байгаатай нягт уялдаатай юм. Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд нь байгууллагын төлбөрийн чадвар нь урт хугацааны туршид ямар байгааг харуулдаг. /хүснэгт 5/

Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд

| Үзүүлэлтүүд | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 |
|--|------|------|------|---------|---------|
| 1. Бие даалтын коэффициент | 0.58 | 0.75 | 0.66 | 0.68 | 0.67 |
| 2. Зохицуулалтын коэффициент | 0.86 | 0.32 | 0.49 | 0.49 | 0.51 |
| 3. Эргэлтийн эргэлтийн бус хөрөнгийн харьцаа | 1.01 | 0.32 | 0.47 | 0.5 | 0.51 |
| 4. Урт хугацаат өр төлбөрийн бүтцийн коэффициент | 0 | 0 | 0 | 0.00584 | 0.00676 |
| 5. Өр төлбөрийн коэффициент | 0.83 | 1.00 | 1.00 | 0.95 | 0.92 |
| 6. Бэлтгэн нийлүүлэгч гэрээ гүйцэтгэгчдэд төлөх өрийн хувийн жин | 0.36 | 0.09 | 0.37 | 0.48 | 0.77 |

Бие даах чадварын коэффициент бараг 60 хувиас их буюу хангалттай байгаа нь санхүүгийн тогтвортой байдал сайн байгааг илэрхийлэх боловч зээлдэн ашиглаж байгаа хөрөнгийн ихэнх хэсэг нь богино хугацаат өр төлбөрийн тооцоо /2005 онд 92%, түүний дотор бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгчдэд төлөх өр /2005 –онд 77%/ эзэлж байна. Санхүүгийн тогтвожилтын байдлыг илэрхийлэх дээрх 4 бүлэг үзүүлэлтүүдийн тогтолцоо нь санхүүгийн байдлыг иж бүрэн харуулах үзүүлэлт хараахан болж чадахгүй боловч санхүүгийн байдлыг шинжлэх, үнэлгээ өгөхөд дараах ерөнхий загвар (дүрслэл)-ыг гаргах боломжтой юм.





АА(х) - Хөрөнгийн ашигт ажиллагаа

ЭХ - Эргэцийн харьцаа

ӨХХ - Өөрийн хөрөнгийн хангалтын коэф

ЭХХ- Эргэлтийн хөрөнгийн эргэц

ЗК - Зохицуулалтын коэффициент




Байгууллагын хэвийн (дампуурлын ба дампуурлын өмнөх) үйл ажиллагааны тогтвортой байдлын хил

Байгууллагын тайлант оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээрх шугам

Дүрслэлийг бүрдүүлэх нь санхүүгийн тогтвортой байдлаа хаана хэдийд ямар байдлаар алдav гэдгийг харах боломж олгоно. 2001-онд санхүүгийн тогтвожилтын хувьд амжилт олсон үе байжээ. Энэ онд ашигт ажиллагааны түвшин хэвийн, санхүүжүүлэх эх үүсвэрийн бүтэц зөв тэнцвэртэй, хөрөнгийн эргэц хурдтай байв. 2002 оноос өөрийн хөрөнгийн эх үүсвэр хүрэлцээтэй, ажил хэрэгч байдал сайн нөлөөтэй байсан ч санхүүгийн тогтвортой байдлаа алдаж эхэлсэн байна. 2002-2005 онд тус үйлдвэр санхүүгийн хямралт байдалд орсон байна.

Судалгааны үр дунд санхүүгийн үйл ажиллагааны дараах дутагдалтай талуудыг илрүүлэв. Оруулсан хөрөнгөөсөө ашиг олох, үйл ажиллагааны тогтвортой өсөлт алдагдан харилцагчдын өмнө найдвартай байх чадваргүй болсон. Хөрөнгийн хөрөнгө чадвар болон төлбөрийн чадварын хувьд балансын бүтэц хангалтгүй болсон байна.

| Үзүүлэлтүүд | Өндөр түвшин (A) | Дунд түвшин (B) | Доод түвшин (C) | 2001 | Түвшин | 2005 | Түвшин |
|---------------------------------------|---------------------|--------------------|--------------------|--------|--------|--------|--------|
| 1. Бие даалтын коэффициент | >0.5 | 0.3-0.5 | <0.3 | 0.58 | A | 0.67 | A |
| 2. Эргэлтийн харьцаа | >2.0 | 1.0-2.0 | <1.0 | 1.21 | B | 1.02 | B |
| 3. Ойрын боломж | >0.8 | 0.4-0.8 | <0.4 | 0.78 | B | 0.58 | B |
| 4. Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа | >0.2 | 0.1-0.2 | <0.1 | 0.0001 | C | 0.0405 | C |
| 5. Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа | >0.1 | 0.05-0.1 | <0.05 | 9.64 | A | -2.9 | C |
| 6. Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа | >0.15 | 0.1-0.15 | <0.1 | 16.48 | A | -4.35 | C |



Бидний сонгон авсан X компани хувьд ойрын үед бодлогоо өөрчлөхгүй бол магадгүй 2-3 жилийн дараа санхүүгийн тогтвортой байдлаа алдах магадлал байна. Санхүүгийн байдлын хувьд 3-р зэргийн ангилалд багтаж байгаагаас үзвэл энэ нь санхүүгийн зарим үзүүлэлт нь доголдож яваа дунд зэргийн компани гэсэн үг. Тогтвортой байдал нь үйл ажиллагааны ашигтай байгаа эсэхээс шууд хамаарна. Судалгаанаас харахад тус компани нь одоо зөвхөн бий болсон нөхцлөө хадгалах төдий л үйл ажиллагаагаа явуулж байгаа гэж дүгнэгдэхээр байна.

Борлуулж боломжтой санхүүгийн хөрөнгөгээж ишнийн изгийн бай болсон ээсэй, аялагч, дуучинчар хутагтаа хүртэй эзмийнх хөрөнгө оруулалт, худалдах дорийнхөөр эзмийнх байгаа санхүүгийн хөрөнгийн бусад санхүүгийн хөрөнгө юм.

Худалдах зорилгоор эзмийнх байгаа орчны узэт цэвэрх

хөрөнгө оруулалт
Investment in trading debt securities "Бадраа" компанийн худалдах зорилгоор эзмийнх байгаа орчны узэт цэвэрх хөрөнгө оруулалтын төслийн мэдээлийн 2006 оны 3-р кварталын

Ном зүй

1.Б.Сайнжаргал "Санхүүгийн тайлангийн шинжилгээ"

2. А.И. Алексеева, Ю.В. Васильев, А.В. Малеева, Л.И. Ушвицкий-М.: КНОРУС

"Комплексный экономический анализ хозяйственной анализа" 2007 495-667

3. Киселев М.В. "Анализ и прогнозирование финансово хозяйственной деятельности организации" –М.Издательство "АиН" 2001 88 -90

4.М.М. Стажкова "Финансовый анализ" Москва 2007 34-48

5. Финансовый менеджмент: теория и практика: Учебник/ Под ред. Е.С.Стояновой 1998 656